



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулж,
сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалт, “Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Стандарт, хэмжил зүйн газарт 2023 оны 04 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах Дулаан даралтын төрлөөр мэргэшүүлэх сургалтад Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн химич инженер Л.Отгонжаргалыг хамруулсугай.

2.Сургалтын төлбөр 120,000 (нэг зуун хорин мянга) төгрөгийг зохих журмын дагуу гарган зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3.Сургалтад хамрагдах ажилтны суралцах хугацаанд ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Оношилгоо, хэмжил зүйн лаборатори (Г.Батцэцэг)-д, сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж, тайланг удирдлагад хүргүүлэхийг Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн химич инженер Л.Отгонжаргалд үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0378